ТӨСӨЛ

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь “Мэдээлэл холбооны мэргэжлийн нэгдсэн холбоо” (цаашид “МНХ” гэх)-ны Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох ажиллагааг ил тод, шударга зарчмаар, Холбооны дүрэмд нийцүүлэн зохион байгуулахад оршино.

1.2 Энэхүү журам нь МНХ-г үүсгэн байгуулах Бүх гишүүдийн хурлын шийдвэрийн хамт хүчин төгөлдөр болно.

1.3 Сонгуулийн үйл ажиллагаанд хууль дээдлэх, ил тод, шударга байх, үүсгэн байгуулагчдын төлөөллийн тэнцвэрийг хангах, сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

Хоёр. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх ба тавигдах шалгуур

2.1 МНХ-г үүсгэн байгуулагч гишүүн мэргэжлийн холбоо нь дүрмийн 9.8-д заасан шаардлагыг хангасан төлөөлөгчийг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэхээр санал болгож болно.

2.2 Бүх гишүүдийн хурлын төлөөлөгч нь МНХ-ны дүрэмд тусгайлан заасан шаардлагыг хангасан тохиолдолд Ерөнхийлөгчийн албан тушаалд өөрийн нэрийг дэвшүүлж болно.

2.3 Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь МНХ-ны дүрмийн 9.8.1-9.8.4-т заасан нийтлэг шаардлагыг хангасан байна.

2.4 Ерөнхийлөгчид нэр дэвшигч бүр МНХ-г хөгжүүлэх, дүрмээр хүлээсэн үүрэг, гадаад харилцаа болон стратеги төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх талаарх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөө бүх гишүүдийн хуралд 5 хүртэл минутын хугацаанд багтаан танилцуулна.

Гурав. Ерөнхийлөгчийг сонгох

3.1 Ерөнхийлөгчийн сонгуулийг бүх гишүүдийн хуралд оролцсон төлөөлөгчдийн [DC1]дунд ил санал хураалтын зарчмаар зохион байгуулна.

3.2 Бүх гишүүдийн хуралд саналын эрхтэй оролцсон нийт төлөөлөгчдийн ердийн олонхын (50%-иас дээш) хувийн санал авсан нэр дэвшигчийг МНХ-ны Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцно.

3.3 Хэрэв эхний санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч ердийн олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан эхний 2 (хоёр) нэр дэвшигчийн хооронд дахин санал хураалт явуулна.

Дөрөв. Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

4.1 МНХ-ны Удирдах зөвлөл нь холбооны дүрэмд заасны дагуу арван гурав (17)-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

4.2 МНХ-г үүсгэн байгуулагч гишүүн холбоод нь МНХ-ны дүрмийн 10.3-т заасан суудлын квотын дагуу өөрийн холбоог төлөөлөх Удирдах зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлж**,** бүх гишүүдийн хуралд танилцуулна.

4.3 Бүх гишүүдийн хурлаар МНХ-ны дүрмийн 10.3-д заасан суудлын квотын дагуу гишүүн холбоо тус бүрээс нэр дэвшүүлсэн Удирдах зөвлөлийн гишүүдийг бүхэлд нь батламжилсан шийдвэр гаргана.

4.4 Бүх гишүүдийн хурлаар батламжилсан тухайн нэр дэвшигчийг МНХ-ны Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно.

Тав. Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох

5.1 МНХ-ны Хяналтын зөвлөл нь тав (5)-аас доошгүй, сондгой тоотой гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.
5.2 МНХ-г үүсгэн байгуулагч гишүүн холбоод нь тус бүр 1 хүртэлх Хяналтын зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлж, бүх гишүүдийн хуралд танилцуулна.
5.3 Бүх гишүүдийн хурлаар гишүүн холбоо тус бүрээс нэр дэвшүүлсэн Хяналтын зөвлөлийн гишүүдийг бүхэлд нь батламжилсан шийдвэр гаргана.
5.4 Бүх гишүүдийн хурлаар батламжилсан тухайн нэр дэвшигчийг МНХ-ны Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно.

Зургаа. Санал хураалт

6.1 Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтыг бүх гишүүдийн хуралд оролцсон төлөөлөгчдийн дийлэнх олонхийн саналаар нууц санал хураалтаар явуулж болно.
6.2 Нууц санал хураалтын саналын хуудасны загвар, тоо ширхэгийг Тооллогын комисс хянан баталж, хурлын төлөөлөгчдөд гарын үсгээр нь олгоно.
6.3 Санал хураалтын хайрцгийг нээх болон саналын хуудас тоолох ажиллагааг Тооллогын комисс бүх гишүүдийн хурлын төлөөлөгчдийн өмнө ил тод, нээлттэй явуулна.

Долоо. Сонгуулийн дүн ба бүрэн эрхийг баталгаажуулах

7.1 Тооллогын комисс сонгуулийн тооллогын дүн гарсан даруйд хурлын төлөөлөгчдөд санал хураалтын дүнг уншиж танилцуулна.
7.2 Тооллогын комиссын танилцуулсан санал хураалтын дүнг үндэслэн бүх гишүүдийн хурлаас "Сонгуулийн дүнг баталгаажуулах тухай" тогтоол гаргана.
7.3 Сонгогдсон Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлийн гишүүд бүх гишүүдийн хурлын тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлнэ.

Найм. Бусад зүйл

8.1 Энэхүү журмаар шууд зохицуулаагүй асуудлыг МНХ-ны дүрэм болон МНХ-г үүсгэн байгуулах бүх гишүүдийн хурлын дэгээр зохицуулна.
8.2 Энэхүү журмыг МНХ-г үүсгэн байгуулах Бүх гишүүдийн хурал анх баталж, хүчин төгөлдөр болно. Цаашид журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг Удирдах зөвлөл батална.

---oOo---